



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2020 оны 12 дугаар
сарын 30-ны өдөр

Дугаар 239

Улаанбаатар
хот

Хилийн боомтын талаар авах
арга хэмжээний тухай

Монгол Улсын хилийн тухай хуулийн 21.2, 28.2, Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх серег нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7.1.19, Улсын онцгой комиссын саналыг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор хилийн бүх боомтоор улсын хил нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрийг дуустал түр зогсоосугай.

2. Хилийн боомтоор нэвтрэх зорчигч тээврийн хөдөлгөөнийг зогсоосонтой холбогдуулан Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талд дипломат шугамаар мэдэгдэхийг Гадаад харилцааны сайд Н.Энхтайван, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Хил хамгаалах ерөнхий газар (Ж.Бямбасүрэн) нарт даалгасугай.

3. Зайлшгүй шаардлагаар улсын хил нэвтрэх иргэд болон эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, гадаадын тусламжаар хүлээн авах бараа материалыг улсын хилээр нэвтрүүлэх асуудлыг тухай бүр шийдвэрлэж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатарт зөвшөөрсүгэй.



Монгол Улсын Ерөнхий сайд

У.ХҮРЭЛСҮХ

Монгол Улсын Шадар сайд

Я.СОДБААТАР

УХААНЫ